

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү журмаар төмөр замын тээврийн байгууллага, салбар зам болон хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигчийн үйл ажиллагаанд гарсан төмөр замын тээврийн осол, зөрчлийг ангилах, шинжлэн шалгах, шалтгаан, нөхцөлийг тогтоох, бүртгэх, мэдээлэхтэй холбогдох харилцааг зохицуулна.

1.2. “Төмөр замын тээврийн осол” гэж төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөнөөс үүдэн хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, иргэн болон хуулийн этгээдийн эд хөрөнгөд хохирол учруулсан үйл явдлыг хэлнэ (цаашид “Осол” гэх).

1.3. Тодорхойлолт

1.3.1. “Төмөр замын тээврийн зөрчил” гэж төмөр замын хөдөлгөөний аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдсөний улмаас осол гарах бодит эрсдэл үүссэн боловч энэ журмын дагуу осолд хамаарахгүй үйл явдлыг хэлнэ (цаашид “Зөрчил” гэх).

1.3.2. Энэхүү журамд хэрэглэсэн “Зөрчил” нь захиргааны хариуцлага ногдуулах эрх зүйн ойлголт бус, төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдлын үйл явдлыг ангилах зориулалттай ойлголт болно.

1.4. Осол, зөрчлийг шинжлэн шалгах үйл ажиллагааны зорилго нь төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлох, түүнийг тасралтгүй сайжруулахад оршино.

1.5. Шинжлэн шалгах ажиллагаа нь осол, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, тайлан гаргах, бүртгэх, үр дагаврыг арилгах, дахин давтагдахаас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэнэ. Уг ажиллагаа нь аливаа этгээдийг буруутгах, хариуцлага ногдуулах зорилгогүй байна.

1.6. Төмөр замын тээврийн байгууллага, салбар зам болон хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч нь энэхүү журамд нийцүүлэн осол, зөрчлийг шинжлэн шалгах, тайлан гаргах, шалтгаан, үр дагаврыг арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх дотоод журам, зааврыг баталж мөрдөнө.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ОСОЛ, ЗӨРЧЛИЙН АНГИЛАЛ

2.1. Төмөр замын тээврийн осол

Дараах үйл явдлын улмаас хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, эд хөрөнгөд их хэмжээний хохирол учирсан буюу хөдлөх бүрэлдэхүүнд дунд болон их засвар хийх шаардлагатай, эсхүл ашиглалтаас хасах хэмжээнд гэмтэл үүссэн, мөн суурь бүтцэд галт тэрэгний хөдөлгөөнийг зогсоох, эсхүл их хэмжээний сэргээн засварлах ажил шаардсан гэмтэл үүссэн тохиолдлыг “Осол”-д тооцно:

2.1.1. Зорчигчийн, ачааны галт тэрэг, сэлгээний бүрэлдэхүүн нь өөр галт тэрэг, хөдлөх бүрэлдэхүүнтэй мөргөлдсөн;

2.1.2. Хөдлөх бүрэлдэхүүн замаас гарсан;

2.1.3. Төмөр замын гарам дээр хөдлөх бүрэлдэхүүн тээврийн хэрэгсэлтэй мөргөлдсөн;

2.1.4. Аюултай ачаа тээвэрлэх, ачих, буулгах явцад аюултай ачаа асгарсан, шатсан, дэлбэрсэн, урвалд орсон;

2.1.5. Төмөр замын зам, замын байгууламж эвдэрч, гэмтсэний улмаас галт тэрэгний хөдөлгөөнд ослын нөхцөл үүссэн;

2.1.6. Вагон, чингэлэгт ачсан ачаа шатсан, дэлбэрсэн;

2.1.7. Галт тэрэгний зурмагийн ноцтой тасалдал үүсч, олон байгууллагын хөдөлгөөнд саатал үүссэн.

2.2. Төмөр замын тээврийн зөрчил

Энэхүү журмын 2.1-д заасан үр дагавар үүсээгүй дараах үйл явдлыг “зөрчил”-д тооцно:

2.2.1. Галт тэрэг, хөдлөх бүрэлдэхүүн хоорондын зам, өртөө, зөрлөг, салбар замд мөргөлдсөн;

2.2.2. Хөдлөх бүрэлдэхүүн замаас гарсан;

2.2.3. Төмөр замын гарам дээр хөдлөх бүрэлдэхүүн тээврийн хэрэгсэлтэй мөргөлдсөн;

2.2.4. Вагон, чингэлэгт ачсан ачаа шатсан;

2.2.5. Галт тэрэгний зурмагийн тасалдал үүссэн;

2.2.6. Галт тэргийг эзэлгээтэй замд хүлээн авсан;

2.2.7. Галт тэргийг эзэлгээтэй хоорондын замд явуулсан;

2.2.8. Бэлэн бус замналаар галт тэрэг хүлээн авсан, явуулсан;

2.2.9. Хөдлөх бүрэлдэхүүн хориглосон дохио өнгөрсөн;

2.2.10. Хөдлөх бүрэлдэхүүний дор сум эргэсэн;

2.2.11. Хөдлөх бүрэлдэхүүн хяналтгүй, удирдлагагүй /өөрөө/ хөдөлсөн;

2.2.12. Хөдлөх бүрэлдэхүүний эд анги хугарсан;

2.2.13. Зорчигчийн вагоныг замд салгасан;

2.2.14. Галт тэрэг гадны биет дайрсан;

2.2.15. Хөдлөх бүрэлдэхүүнийг төгсгөлийн кран хаалттай явуулсан;

2.2.16. Зорчигчийн галт тэрэгний зүтгүүр техникийн гэмтлийн улмаас зогсож, тусламж авсан;

2.2.17. Техникийн гэмтлийн улмаас зорчигчийн галт тэрэгний хөдөлгөөнийг цуцалсан эсхүл зорчигчдыг буулгасан;

2.2.18. Хөдлөх бүрэлдэхүүний эд анги зам дээр унасан;

2.2.19. Ачааны техникийн нөхцөл зөрчигдсөний улмаас вагоныг замд салгасан;

2.2.20. Дохио хориглох эсхүл хурд бууруулах заалт өгөх ёстой байхад зөвшөөрөх заалт өгсөн;

2.2.21. Авто угсраа салсан, тасарсан;

2.2.22. Сум зүсэгдсэн;

2.2.23. Аюултай ачаа асгарсан, алдагдсан;

2.2.24. Аюултай ачаа тээвэрлэж буй вагоныг техникийн гэмтлийн улмаас салгасан;

2.2.25. Зам төмөр тасарсан, ухагдсан;

2.2.26. Хөдлөх бүрэлдэхүүн машин механизм, тоног төхөөрөмж, гадны биеттэй мөргөлдсөн;

2.2.27. Хөдлөх бүрэлдэхүүн зөвшөөрөлгүйгээр өртөө, замд нэвтэрч хөдөлгөөнд оролцсон;

2.2.28. Галт тэрэг мал, том амьтан дайрсан;

2.2.29. Зөвшөөрөгдсөн хурдыг 20 км/ц ба түүнээс дээш, эсхүл тогтоосон хурдын 30 хувиас дээш хэмжээгээр хэтрүүлсэн;

2.2.30. Төмөр замын хамгаалалтын бүсэд тогтоосон журмыг зөрчин нэвтэрсэн;

2.2.31. Техникийн гэмтэл, зохион байгуулалтын алдаанаас шалтгаалан галт тэрэгний хөдөлгөөн хоорондын замд 1 цаг ба түүнээс дээш хугацаагаар бүрэн саатсан;

2.2.32. Галт тэрэгний хөдөлгөөнд аюул учруулах нөхцөл үүссэн байхад аюултай хэсгийг тогтоосон журмын дагуу дохио, тэмдэг, хамгаалалтаар хангаагүй;

2.3. Төмөр замын тээврийн байгууллага нь үйл ажиллагааны онцлогоос хамааран энэхүү журмын 2.2-т заасан зөрчлөөс гадна бусад ижил шинжтэй үйл явдлыг зөрчилд тооцож, бүртгэж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШАЛГАХ ЭТГЭЭД БОЛОН ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Ослыг шинжлэн шалгах

3.1.1. Энэхүү журмын 2.1-д заасан ослоос дараах үр дагавар бүхий ослыг төрийн захиргааны төв байгууллагаас томилсон шинжлэн шалгах баг ахалж шинжлэн шалгаж, тайлан гаргана. Үүнд:

- хүний амь нас хохирсон;
- гурав ба түүнээс дээш хүн хүнд гэмтсэн;
- аюултай ачааны дэлбэрэлт, гал түймэр, хорт бодисын алдагдал үүссэн;
- хөдлөх бүрэлдэхүүн ашиглалтаас хасагдах хэмжээний гэмтэл авсан;
- суурь бүтцэд ноцтой эвдрэл үүсч, хоорондын замын хөдөлгөөн 6 цаг ба түүнээс дээш хугацаагаар бүрэн зогссон;
- байгаль орчинд ноцтой сөрөг нөлөө үзүүлсэн.

3.1.2. Шинжлэн шалгах баг нь мэргэшсэн шинжээч нараас бүрдэх бөгөөд шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагын мэргэжилтэн, хараат бус шинжээчийг оролцуулж болно.

3.1.3. Шинжээчийн эрх:

- Осол болсон газар болон холбогдох объектод саадгүй нэвтрэх;
- Холбогдох этгээдээс тайлбар, мэдээлэл авах;
- Баримт бичиг, техник хэрэгслийн мэдээлэлтэй танилцах, шалгах;
- Хөдөлгөөний бүртгэлийн төхөөрөмжийн мэдээллийг шалгах;
- Шаардлагатай бол шинжилгээ, туршилт хийлгэх.

3.1.4. Энэхүү журмын 3.1.1-д заасан шалгуурт хамаарахгүй ослыг Төрийн захиргааны байгууллагын хяналтын улсын ахлах байцаагч хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд шинжлэн шалгаж, тайлан гаргана.

3.2. Зөрчлийг шинжлэн шалгах

3.2.1. Энэхүү журмын 2.2-т заасан зөрчлийг төмөр замын тээврийн байгууллага, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч дотоод журмын дагуу шинжлэн шалгаж, дүгнэлт, тайлан гаргана.

3.3. Байгууллагын дотоод шалгалт

3.3.1. Осол, зөрчил гарсан тохиолдолд төмөр замын тээврийн байгууллага, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч нь дотоод шалгалтыг нэн даруй зохион байгуулж, шалтгаан, нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.4. Урьдчилан сэргийлэх зөвлөмж

3.4.1. Шинжээч, улсын байцаагч, төмөр замын байгууллагын дотоод шалгалтын нэгж нь осол, зөрчил дахин гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөмж гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлнэ.

3.5. Шуурхай мэдээлэх

Осол, зөрчил гарсан тухай мэдээллийг тухайн байгууллага нэн даруй, аль болох 1 цагийн дотор дараах байгууллагад мэдэгдэнэ:

- төрийн захиргааны төв байгууллага;
- төрийн захиргааны байгууллага;
- төмөр замын тээврийн хяналтын улсын ахлах байцаагч, улсын байцаагч;
- онцгой байдлын байгууллага;
- эмнэлгийн байгууллага;
- цагдаагийн байгууллага.

3.6. Шуурхай мэдээллийн агуулга

Шуурхай мэдээлэлд:

- осол, зөрчил болсон газар;
- огноо, цаг;

- нөхцөл байдал;
- урьдчилсан хохирлын мэдээлэл;
- холбогдох байгууллагын нэр;
- мэдээлэл өгсөн этгээдийн нэр, албан тушаал, холбоо барих мэдээлэл тусгагдсан байна.

3.7. Бичмэл мэдээлэл

3.7.1. Шуурхай мэдээллийг өгснөөс хойш 12 цагийн дотор бичгээр баталгаажуулж, холбогдох байгууллагад хүргүүлнэ.

3.8. Зөрчлийн мэдээлэл

3.8.1. Төмөр замын зөрчлийн мэдээллийг сар бүрийн 10-ны дотор төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

3.9. Ангилал өөрчлөх

3.9.1. Зөрчлийн мэдээллийг хянаж шаардлагатай тохиолдолд **шинжээч, улсын ахлах байцаагчийн** шийдвэрээр тухайн үйл явдлыг дахин ангилж, шинжлэн шалгаж болно.

3.10. Төмөр замын тээврийн байгууллага, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч этгээдийн үүрэг

- 3.10.1. хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалж анхан шатны тусламж үзүүлэх;
- 3.10.2. энэ журмын 3.5, 3.7-д заасны дагуу шуурхай болон бичмэл мэдээллийг хүргүүлэх;
- 3.10.3. осол, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтооход ашиглагдаж болох баримт бичиг, замын байгууламж болон хөдлөх бүрэлдэхүүний эд анги, бүрдэл хэсэг, эд зүйлийг хэвээр нь хадгалж, хамгаалах, дуу, дүрс бичлэгээр баримтжуулах;
- 3.10.4. хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд зайлшгүй шаардлагатай бол шинжээч, улсын байцаагчид мэдэгдэж осол, зөрчлийн улмаас эвдэрч гэмтсэн хөдлөх бүрэлдэхүүн, барилга, байгууламж, эд зүйлсийг эвдэх, задлах, нээх, замаас зайлуулах, ослын газар болон аюултай бүсийг хамгаалалтад авах, татан буулгах, аюултай ачааны хор хөнөөлийг саармагжуулах зэрэг шуурхай арга хэмжээ авах;
- 3.10.5. осол, зөрчил гарсан газарт шинжээч, улсын байцаагчийг саадгүй нэвтрүүлэх, холбогдох баримт бичиг буюу илчит тэрэгний хурд хэмжигч, мэдээлэл бүртгэгчийн мэдээлэл /тууз/, бусад цуглуулсан нотлох баримтыг шинжээч, улсын байцаагч болон дотоод шалгалтын багт гаргаж өгөх;

3.11. Төмөр замын тээврийн байгууллага, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч нь осол болсон газрын үзлэг дууссаны дараа шинжээч, улсын ахлах байцаагчийн зөвшөөрлөөр суурь бүтэц болон хөдөлгөөн сэргээх ажлыг эхлүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ

4.1. Шинжлэн шалгах ажиллагаа нь хараат бус, бие даасан байж, осол, зөрчил гарсан шалтгаан, нөхцөлийг үнэн, зөв тогтоох, цаашид давтан гарахаас урьдчилан сэргийлэхэд чиглэнэ.

4.2. Төрийн захиргааны төв байгууллага осол, зөрчлийн шалтгаан тогтоох, тайлан гаргах заавар баталж, хэрэгжүүлнэ.

4.3. Шинжилгээ, туршилт хийх зардлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

4.4. Төмөр замын тээврийн байгууллага нь осол, зөрчил гарсан газарт ажиллах шинжлэн шалгах баг, шинжээч, улсын байцаагчийг шаардлагатай хамгаалах хувцас, хэрэгсэл, тоног төхөөрөмж, холбооны болон тээврийн хэрэгслээр хангана.

4.5. Осол, зөрчлийг шинжлэн шалгах, шалтгааныг нь тогтоох, бүртгэх үйл ажиллагаа нь мэдээлэл цуглуулах, холбогдох баримт бичиг бүрдүүлэх, судлан шинжлэх, дүн шинжилгээ хийх, тайлан гаргах, мэдээлэх, архивлах гэсэн дарааллаар явагдана.

4.6. Осол, зөрчил гарсан үед төмөр замын тээврийн байгууллага, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч нь осол, зөрчил гарсан газарт шинжлэн шалгах баг, шинжээч, улсын байцаагч хүрэлцэн ирэхээс өмнө тэдэнд мэдэгдэж, осол, зөрчлийн нөхцөл байдлаас хамааран дараах ажил, үүргийг гүйцэтгэнэ:

4.6.1. хурд хэмжигчийн тууз, галт тэрэгний хөдөлгөөний мэдээллийг бүртгэх төхөөрөмж /мэдээлэл хадгалагч/, галт тэрэгний биечилсэн хуудас, тоормосны хангамжийн мэдээлэл, хурд хязгаарласан тухай анхаарамж, зүтгүүрийн ширээний журнал, бусад баримт бичиг, бүртгэлийн мэдээллийг хадгалж, шаардлагатай бол хуулбарлан авах;

4.6.2. осол, зөрчил гарсан газар, суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдалд үзлэг хийсэн тухай акт үйлдэх;

4.6.3. суурь бүтэц, замын байгууламж болон хөдлөх бүрэлдэхүүний гэмтлийг тодорхойлох;

4.6.4. осол, зөрчлийн нөхцөл байдал, суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний байдал, эвдрэл, гэмтэл, гаднын болон ойр орчимд байгаа эд зүйлсийг гэрэл зураг, дуу, дүрс бичлэгээр баримтжуулах;

4.6.5. осол, зөрчилд холбоотой ажилтан, гэрчийн этгээдээс бичгээр тодорхойлолт авч, шаардлагатай бол дуу, дүрс бичлэгээр баримтжуулах;

4.6.6. осол, зөрчил болсныг баримтжуулах зорилгоор авсан гэрэл зураг, дуу, дүрс бичлэг, ослын дараах суурь бүтцийн тоног төхөөрөмж, хөдлөх бүрэлдэхүүний гэмтэл, арчлалтын норм хэмжээний өөрчлөлт, хөдлөх бүрэлдэхүүний байршил, замаас гарсан эхлэл, төгсгөлийн ул мөрийг заасан бүдүүвч зураг гаргах;

4.6.7. осол, зөрчил гарах үеийн цаг агаарын байдлын талаар тэмдэглэл хийж, шаардлагатай бол холбогдох баримтыг авах.

4.7. Ослыг шинжлэн шалгах баг, шинжээч нь ослын шалтгаан, нөхцөлийг тогтоож, тайланг боломжит богино хугацаанд боловсруулна. Тайлангийн төслийг осол, зөрчилд холбогдогч байгууллагад хүргүүлж, баримт мэдээллийн зөрүү, техникийн алдаа, үндэслэл бүхий тайлбартай холбоотой саналыг төслийг хүлээн авснаас хойш 7 /долоо/ ажлын өдрийн дотор бичгээр ирүүлэхийг мэдэгдэнэ. Ирүүлсэн саналыг шинжлэн шалгах баг хянаж үзээд, үндэслэлтэй гэж үзсэн саналыг тусгана. Үндэслэлгүй гэж үзсэн саналыг тайланд хавсаргана. Тогтоосон хугацаанд санал ирүүлээгүй бол тайлангийн төслийг зөвшөөрсөнд тооцож, эцсийн тайланг баталгаажуулна.

4.8. Шинжлэн шалгах багийн шийдвэрийг олонхийн саналаар гаргана. Санал нийлэхгүй шинжээч өөрийн тусгай саналыг тайланд хавсаргана.

4.9. Осол, зөрчлийн шалтгааныг нь тогтоохдоо нотлох баримт, суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн тэдгээрийн эд анги, техник, тоног төхөөрөмжийг эвдэж гэмтээхгүй, үрэгдүүлэхгүй, сөрөг нөлөөлөл үзүүлэхгүйгээр ажиллах, шаардлагатай бол томоохон эд анги болон аюултай ачааг зөөвөрлөн саадгүйгээр шилжүүлэхдээ холбогдох шинжээч, улсын байцаагчийн зөвшөөрлөөр, мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор гүйцэтгүүлнэ.

4.10. Дараах мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад задруулахгүй. Үүнд:

4.10.1. холбогдогч, гэрч, бусад этгээдээс авсан тайлбар, тодорхойлолт, мэдүүлэг;

4.10.2. акт, шинжлэн шалгах ажиллагааны фото зураг, дуу, дүрс бичлэг, бүдүүвч зураг, хурдны бичлэг, илчит тэрэгний техникийн үзүүлэлтийн мэдээлэл;

4.10.3. осол, зөрчилд өртсөн, хохирсон хүний эрүүл мэнд, хувь хүний мэдээлэл;

4.10.4. гарсан осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд оролцогчийн санал, тайлан, тэдгээртэй холбоотой мэдээлэл;

4.10.5. гарсан осол, зөрчлийг шинжлэн шалгагч нарын хүрээнд болсон бодит хяналтын төхөөрөмжийн бичлэгийн талаарх аливаа үнэлэлт, тодорхойлолт, тайлан.

4.11. Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд гарсан осол, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээг төрийн захиргааны байгууллага болон төмөр замын тээврийн байгууллага, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч төлөвлөн хэрэгжүүлнэ.

4.12. Энэхүү журмын 2.1, 2.2 дахь заалтад заасан нөхцөл байдал үүссэн үед хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдалд үзлэг хийх болон дахин ашиглах боломжгүй, их засварт оруулах хэмжээний эвдрэлтэй эсэх акт гаргахад төмөр замын тээврийн хяналтын улсын байцаагчийг оролцуулна.

4.13. Осол, зөрчлийн тайланд шинжлэн шалгах ажиллагааны явцад цуглуулсан мэдээллээс гадна дараах баримт, мэдээллийг хавсаргана.. Үүнд:

4.13.1. гэмтсэн, хохирсон хүмүүсийн нэрсийн жагсаалт, шинжээчийн дүгнэлт;

4.13.2. хохирлын хэмжээг тодорхойлсон баримт;

4.13.3. шаардлагатай тохиолдолд хийгдсэн шалган турших ажиллагааны акт, дүгнэлт;

4.13.4. галт тэрэгний хөдөлгөөний гүйцэтгэсэн зурмагийн хуулбар;

4.13.5. суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтын үеийн техникийн баримт бичиг, бүртгэл, тайлангийн хуулбар /осол, зөрчлийн шалтгааныг тогтооход шаардлагатай бол/;

4.13.6. осол, зөрчил болсныг баталгаажуулах зорилгоор авсан гэрэл зураг, дуу, дүрс бичлэг, ослын дараах суурь бүтцийн тоног төхөөрөмж, хөдлөх бүрэлдэхүүний гэмтэл, арчлалтын норм хэмжээний өөрчлөлт зэргийг заасан бүдүүвч зураг;

4.13.7. тухайн үеийн цаг уурын байдлын талаарх лавлагаа;

4.13.8. техникийн мэдлэгийн шалгалтын баримт, ажлын байрны тодорхойлолт, дадлага туршлагын байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаанд хамрагдсан эсэх, эмнэлгийн үзлэгт орсон тухай магадалгаа, ажил, амралтын дэглэмийн тухай мэдээлэл;

4.13.9. шаардлагатай бусад баримт.

4.14. Осол, зөрчлийн шинжлэн шалгах тайлан нь гэм бурууг тогтоох зорилготой баримт бичиг биш.

ТАВДУГААР БҮЛЭГ ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ БҮРТГЭХ

5.1. Төрийн захиргааны төв байгууллага нь энэхүү журмын 2.1-д заасан ослын ангиллыг эцэслэн тогтоож, улсын хэмжээнд нэгдсэн бүртгэл хөтөлнө.

Ослын бүртгэлд дараах мэдээллийг тусгана:

- осол гарсан огноо, цаг, газар;
- ослын төрөл, ангилал;
- үр дагаврын шинж чанар;
- хүний амь нас, эрүүл мэндэд учирсан хохирол;
- хөдлөх бүрэлдэхүүн, суурь бүтцийн гэмтлийн байдал;
- урьдчилан сэргийлэх арга хэмжээ.

5.2. Төрийн захиргааны байгууллага нь энэхүү журмын 2.2-т заасан зөрчлийн бүртгэлийг хөтөлж, улсын хэмжээнд нэгтгэнэ.

5.3. Төмөр замын тээврийн байгууллага, салбар зам болон хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч нь өөрийн байгууллагад гарсан осол, зөрчлийг бүртгэж, холбогдох баримт материалыг холбогдох хууль тогтоомж болон архив, албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу хадгална.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

6.1. Осол, зөрчлийн шинжлэн шалгалтын дүнгийн талаарх товч мэдээллийг ил тод байдлыг хангах зорилгоор холбогдох байгууллага олон нийтэд мэдээлж болно.

6.2. Нийтэд мэдээлэхдээ дараах мэдээллийг тусгана:

- осол, зөрчил гарсан огноо, газар;
- осол, зөрчлийн төрөл, ангилал;
- үр дагаврын ерөнхий мэдээлэл;
- урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээ.

6.3.

Нийтэд мэдээлэхдээ дараах мэдээллийг задруулахыг хориглоно:

- хувь хүний нууц, хувийн мэдээлэл;
- мөрдөн шалгах ажиллагаанд саад учруулах мэдээлэл;
- улсын болон байгууллагын нууцад хамаарах мэдээлэл.

6.4.

Ноцтой үр дагавартай ослын талаарх мэдээллийг төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн байдлаар нийтэд мэдээлнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

7.1. Энэхүү журмын хэрэгжилтэд төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, төмөр замын тээврийн байгууллага, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч нь өөр өөрийн бүрэн эрх, чиг үүргийн хүрээнд хяналт тавьж, биелэлтийг хангуулна.

7.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

7.3. Хариуцлага хүлээлгэхтэй холбоотой зохицуулалт

7.3.1. Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах үүргээ биелүүлээгүй, осол, зөрчлийг шинжлэн шалгахад саад учруулсан, эсхүл шуурхай арга хэмжээ авах үүргээ биелүүлээгүй бол Зөрчлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

7.3.2. Осол, зөрчилтэй холбоотойгоор худал мэдүүлэг өгөх, баримт бичиг, нотлох баримтыг нуун дарагдуулах, устгах, гэмт хэрэг нуун далдлах үйлдэл гаргасан бол Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

Зам, тээврийн сайдын 20 . . . оны . . . дугаар
сарын . . . -ны өдрийн . . . дүгээр тушаалын
“Төмөр замын тээврийн осол, зөрчлийг
шинжлэн шалгах журам”-ын нэгдүгээр
хавсралт

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙН ШУУРХАЙ БИЧМЭЛ МЭДЭЭЛЭЛ

1. Осол, зөрчил гарсан газар /нийслэл, аймаг, сум, баг, хороо, өртөө, хоорондын зам, км, зуут/:
2. Осол, зөрчил гарсан огноо, цаг, минут:
3. Осол, зөрчилтэй холбоотой төмөр зам суурь бүтэц, тээвэрлэгч, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч:
4. Хэрэг явдал болон осол, зөрчлийн нөхцөл байдал /ангилал/:
5. Хүний амь нас, эрүүл мэндэд учирсан хохирол:
6. Осол, зөрчилд өртсөн объектууд /суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, ачаа эвдэрсэн/:
7. Байгаль орчинд учирсан хохирол:
8. Осол, зөрчилд төмөр замын тээврийн бус этгээдийн эд хөрөнгө, үйл ажиллагаанд учирсан хохирол:
9. Осол, зөрчлийн шалтгаан /боломжтой бол урьдчилсан байдлаар/:
10. Осол, зөрчлийн газарт ахалж ажиллаж байгаа албан тушаалтны нэр, утасны дугаар:
11. Хэргийн газарт үзлэг хийж байгаа цагдаагийн байгууллагын албан хаагчийн нэр, утасны дугаар:
12. Нөхцөл байдлыг түргэн шийдвэрлэх зорилгоор хийсэн үйлдлүүд:
13. Осол, зөрчлийн фото зураг, дүрс бичлэг /шаардлагатай бол нэмэлтээр/:

Шуурхай мэдээлэл өгсөн:

/байгууллага, ажилтны овог нэр, гарын үсэг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг/

... оны ... дугаар сарын ...-ны өдөр
... цаг ... минут

Анхаарах нь:

1. Осол, зөрчлийн аль нь болохыг урьдчилсан байдлаар тогтоож бичнэ.
2. Асуултад аль болох дэлгэрэнгүй бичнэ, товчилсон үг хэрэглэхгүй.
3. Осол зөрчлийн фото зураг, нотлох баримт хавсаргаж болно.

